

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 428, А/218.

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/142, А/47 дугаар тушаалаар баталсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж, үйлчлэх журам”-д дор дурдсан агуулга бүхий 2.1¹ дэх заалтыг нэмсүгэй.

1/.”2.1¹.Хорих байрны эмч “согтууруулах ундаа, мансууруулах (опиодын төрлөөс бусад эм, бодис) эм, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн нь энэ журмын 2.1 дэх заалтад заасны дагуу тогтоогдсон, хордлогын шинж илэрсэн хоригдсон этгээдэд (орчноо мэдрэх чадваргүй, цаг хугацаа орон зайн баримжаа алдагдсан, зан ааш болон үйл хөдлөл тогтворгүй болсон, хэт хөөрч баярлах, гутрах, айж цочирдох, хүүхэн хараа гэрлийн урвал өгөхгүй байх, хэл яриа, хөдөлгөөний тэнцвэр алдагдсан) холбогдох стандарт, зааврын дагуу хордлого тайлах эмчилгээнд хамруулна. Шаардлагатай гэж үзвэл лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас цахимаар болон эмч дуудлагаар зөвлөгөө авч болно.”

2. Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/142, А/47 дугаар тушаалаар баталсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж, үйлчлэх журам”-ын 2.1 дэх хэсгийн “сэтгэц” гэсний дараа “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн эсэх” гэж, “тодорхойлон” гэсний дараа “согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодис хэрэглэсэн бол ямар төрлийн бодис хэрэглэснийг асуумж, үзлэг, согтуурал, мансуурал шалгах тест (оношлуур, драгер гэх мэт)-ээр шалгаж” гэж тус тус нэмсүгэй.

3. Эрүүл мэндийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/142, А/47 дугаар тушаалаар баталсан “Хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эмнэлгийн байгууллагад эмчлэх, хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж, үйлчлэх журам”-ын 2.1 дэх хэсгийн “эмнэлгийн мэргэжилтэн” гэснийг “эмч” гэж, журмын 3.1 дэх хэсгийн “Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт” гэснийг “Нийслэл дэх цагдан хорих төвийн эмнэлэг” гэж, журмын 3.3 дахь хэсгийн “хордлого” гэснийг “опиодын хордлого” гэж тус тус өөрчилсүгэй.

4. Энэхүү тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулсныг Улсын ерөнхий прокурорын газар (Б.Жаргалсайхан), Авлигатай тэмцэх газрын дарга (тэргүүн комиссар З.Дашдаваа), Тагнуулын ерөнхий газрын дарга (бригадын генерал П.Одонбаатар) нарт мэдэгдэхийг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга

(Н.Мягмар)-д, мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга (хурандаа Б.Нандинболор), Цагдаагийн ерөнхий газрын дарга (бригадын генерал Т.Сүхболд), аймаг, сум, дүүргийн нэгдсэн эмнэлэг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн дарга, захирал нарт даалгасугай.

5.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Д.Очирбат), Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга (Н.Мягмар) нарт даалгасугай.

